



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 03 өдөр

Дугаар А/384

Улаанбаатар хот

「Улаанбаатар хотын Захирагчийн ажлын
албаны эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасаж
залруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 3,870,999,875.75 (гурван тэрбум найман зуун далан сая есөн зуун ерэн есөн мянга найман зуун далан таван төгрөг далан таван мөнгө) төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг данс бүртгэлээс хасаж, залруулга хийхийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Т.Гантөмөр)-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, зарчмыг баримтлан данснаас хасаж, залруулан өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (Т.Гантөмөр)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА



М.БАЯРАА

115050001063



Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2021 оны 17 дугаар сарын 03/А/394-ны дугаар тушаалын хавсралт

Данснаас хасаж залруулах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба

Д/Д	Эд хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ЭБХХХ Комиссын хурлын шийдвэр
1	Төв цэнгэлдэх байгууламжийн тоног төхөөрөмж	2016	Иж бүрдэл	1	3,870,999,875.75	3,870,999,875.75	-	3,870,999,875.75	Давхар бүртгэсэн тул залруулж данснаас хасах	Залруулах
Бусад үндсэн хөрөнгийн дүн					1	3,870,999,875.75	-			
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						3,870,999,875.75				